

2

“ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Н.Болор

Удиртгал

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээрх эрдэс түүхий эдийн үнэ ханшийн өсөлтүүдээс үүдэн уул уурхайн салбар Монгол улсын эдийн засагт улам бүр томоохон байр суурийг эзлэх боллоо. 2007 оны байдлаар ДНБ-ний 30 орчим хувь, экспортын орлогын 80 гаруй хувийг тус салбар дангаараа бүрдүүлж байна (АМГТХЭГ 2007). Эрдэс түүхий эдүүдийн үнийн өсөлтийн нөлөөллөөс гадна тус салбарт үйлчилж байсан харьцангуй либерал эрх зүйн орчин, дэлхийн хамгийн эрчимтэй өсч буй, хамгийн их багтаамжтай эдийн засгийн хөрш зэрэг хүчин зүйлүүд ч Монгол улсын уул уурхайн салбарын эрчимтэй өсч хөгжих хандлага ажиглагдаж байгаагийн нэг үндэс юм. Харамсалтай нь өнгөрсөн 2-3 жилд болж өнгөрсөн уул уурхайн салбарын бодлогын томоохон өөрчлөлтүүд нь салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж эхлээд байна.

2006 онд Монгол Улсын Их Хурлаас “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” буюу тодруулбал алт, зэсийн үнийн өсөлтийн 68 хувийн татварын хуулийг баталсан нь хөрөнгө оруулагчдыг цочролд оруулсан. Тус хуулийг батлахаас өмнө болон дараа тус хуулийн эдийн засгийн үндэслэл, үр нөлөөг тодорхойлох судалгаа огт хийгдээгүй байна. Иймд энэхүү хуулийн эдийн засгийн нөлөө, үндэслэлийн судалгааг хийлээ. Энэхүү судалгаа нь бусад улс орнуудын ижил төстэй хуулиудын жишээ, сургамж, тус хуулийн талаарх гадаадын судлаачид, олон улсын байгууллагуудын өгсөн зөвлөмж, гэнэтийн ашгийн татварын макро эдийн засгийн нөлөөлөл болон үйлдвэрлэл экспортод үзүүлсэн нөлөө, Монгол улсад алт олборлогчдын

төлөөлөл болох компаниудын түүвэр судалгаан дээр боловсруулсан алтны нэгжийн өөрийн өртгийн шинжилгээ, алтны үйлдвэрлэлийн өртөг ба татварын ачаалалын симуляци шинжилгээ, алт олборлогчдын голлох татваруудын ачаалал алтны дэлхийн зах зээлийн үнээс хэрхэн хамаарч байгааг харуулах үнийн мэдрэмжийн шинжилгээ, судалгааны үр дүнд суурилсан дүгнэлт, бодлогын зөвлөмжийг агууллаа.

I. Монгол улс дахь гэнэтийн ашгийн татварын хууль ба бусад улс орнууд дахь хэрэгжилт

Олон нийтийн дунд “Гэнэтийн ашгийн татварын хууль” гэж нэрлэгдэж буй “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын тухай хууль” нь 2006 оны 5 сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас батлагджээ. “Зарим бүтээгдэхүүний” гэсэн ерөнхий нэртэй боловч алт, зэсийн баяжмал гэсэн ердөө хоёрхон эрдэс түүхий эдийн хувьд хэрэглэгдэх эрх зүйн зохицуулалтын баримт бичиг юм. Хуулийн үндсэн зорилго нь дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнийн өсөлтөөс илүү их хувийг төсөвт оруулах, улмаар энэхүү төсөвт төвлөрсөн нэмэлт мөнгөн хөрөнгөөр Хөгжлийн Сан хэмээх төсвөөс тусдаа санг бүрдүүлж, нийгмийн халамжийн хөтөлбөрүүд болон хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлэх явдал байсан болно.

Тус хуулийн дагуу алт борлуулагч аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүс нэг унц алтны суурь үнэ болох 500 ам.доллар болон борлуулах үеийн зах зээлийн үнийн зөрүүгээс 68 хувийн татвар, зэсийн баяжмал борлуулагч нь нэг тонн зэсийн баяжмалын суурь үнэ болох 2600 ам.доллар болон зэсийн баяжмал борлуулах үеийн нэг тонн зэсийн зах зээлийн үнийн зөрүүгээс 68 хувийн татвар төлж байгаа². Монгол улсын Засгийн газартай “Тогтвортой Байдлын Гэрээ” хийсэн аж ахуйн нэгжүүдийн хувьд тус хууль хамаарахгүй бөгөөд татвар тооцох алт болон зэсийн баяжмалын суурь үнэ нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс үл хамаарахаар тогтоогдсон болно. Мөн гэнэтийн ашгийн татварыг аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар ногдох орлогоос хасч тооцохоор хуульчилсан байна³.

Гэнэтийн ашгийн татвар нь дэлхийн улс орнуудад өнгөрсөн хугацаанд бараг хэрэглэгдээгүй бөгөөд зарим нэг тохиолдлууд байсан боловч маш богино хугацаад үйлчилж байжээ. Тэдгээр цөөн хэдэн тохиолдлуудыг товч авч үзье.

АНУ-ын эдийн засгийн түүхэнд “гэнэтийн ашгийн” татвар нэлээд олон удаа хэрэглэгдсэн байдаг бөгөөд ихэнхдээ дэлхийн дайн болон дэлхий нийтийг хамарсан үнийн хямралын үеүдэд авч хэрэгжүүлсэн байдаг. 1978-1980 онд гэнэт бий болсон газрын тосны үнийн өсөлтөөс олж буй хэт их ашгаас татвар авах нь зүйтэй гэх үзэл тухайн үед нийтийг хамарч, “Түүхий нефтийн гэнэтийн ашгийн татвар”-ын хуулийг ерөнхийлөгч Жеймс Картер 1980 онд баталсан

² “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” 2006.

³ “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль” шинэчилсэн найруулга, 2006

байна. 1980 онд батлагдсан энэхүү хуулийн хүрээнд гэнэтийн ашгийн татвараас 10 жилийн хугацаанд нийт 320 тэрбум ам.долларын нэмэлт орлогыг Холбооны төсөвт оруулна гэж төлөвлөж байсан боловч жинхэнэ гүйцэтгэлээр ердөө 80 орчим тэрбум ам.долларын орлого л төсөвт оруулсан байна. 1981 оноос газрын тосны үнэ огцом буурснаас 1987, 1988 онуудад гэнэтийн ашгийн татвар нь Холбооны төсөвт татварын орлого бараг оруулаагүй байна. Энэ бүх бодит байдал, бусад сөрөг нөлөөллүүдээс үүдэн 1988 онд “Түүхий нефтийн гэнэтийн ашгийн татварын хууль”-ийг хүчингүй болгосон байна. Конгрессийн Төсвийн Хэлтсийн шинжээч Salvatore Lazzari (1990)-ийн хийсэн судалгаагаар 1981 онд батлагдсан газрын тосны гэнэтийн ашгийн татвар нь дотоодын түүхий нефтийн үйлдвэрлэлийг 3-6 хувиар бууруулж, АНУ-ын түүхий нефтийн импортыг 8-16 хувиар нэмэгдүүлж, тус улсын түүхий нефтийн гаднаас хамаарах хамаарлыг нэмэгдүүлсэн байна.

Их Британийн дэд бүтцийн компаниудын хувьчлалын дараа хувьцааны ханшийн өсөлтийн гэнэтийн ашгийн татварын хууль 1997 онд батлагдсан бөгөөд уг хуулийг батлуулах гол үндэслэл нь Их Британийн эдийн засагт чухал үүрэг нөлөөтэй байсан дэд бүтцийн томоохон компаниудыг бирж дээр хувьцаа худалдах замаар хувьчлахдаа нэгж хувьцааны үнийг зах зээлийн үнээс хэт доогуур тогтоосон гэж үзсэнтэй холбоотой юм. Тус хуулийг баталснаар зөвхөн 1997-98 онд ус, цахилгаан хангамж, харилцаа холбоо, эрчим хүчний зэрэг хувьчлагдсан нийт 33 компанийн “хэт ашиг”-аас 5.2 тэрбум паундын нэмэлт орлого Засгийн газрын төсөвт оруулж, залуучуудын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор байгуулсан “Ажил эрхлэлтийн сан”-д төвлөрүүлсэн байна (Chennells, 1997).

Дэлхийн зэсийн үйлдвэрлэлийн салбарт томоохон байр суурь эзэлдэг Замби улсын Засгийн Газраас саяхан буюу 2008 оны 4 сард тус улсын зэсийн баяжмалын үйлдвэрлэлийн татварын хувь хэмжээнд өөрчлөлт оруулахаас гадна шинээр гэнэтийн ашгийн татварыг ногдуулахаар болсон. Ингэснээр тус улсын экспортын орлогын 70 орчим хувийг бүрдүүлдэг зэсийн үйлдвэрлэлийн хувьд татварын нийт хувь 31 байснаа 47 хувь болж нэмэгдээд байна. Одоогоор тус татварын орчны өөрчлөлт тус улсын уул уурхайн салбарын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт болон эдийн засгийн бусад салбаруудад хэрхэн нөлөөлсөн талаар судалгаа хийгдээгүй байна.

II. Монгол улс дахь гэнэтийн ашгийн татварын талаар хийгдсэн судалгаанууд

Жеймс Оттогийн (Otto, 2007) “Монгол улсын уул уурхайн татварын орчны өрсөлдөх чадварын судалгаа”-гаар гэнэтийн ашгийн 68 хувийн татвар нь хөрөнгө оруулагчдын хувьд дор хаяж 12 байхыг шаарддаг хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн хувийг 8.6%, салбарын татварын ерөнхий түвшинг 67.9%-д хүргэж, судалгаанд харьцуулж буй 20 улс дотор Монгол улс хамгийн өндөр татвартайд тооцогдож, Монгол улсын уул уурхайн татварын системийн өрсөлдөх чадварыг эрс бууруулж байгааг харуулсан.

Мөн 2007 онд ОУВС-ийн экспертүүдийн хийсэн судалгаа (IMF, 2007)-гаар “Гэнэтийн ашгийн татварын хууль” батлагдсанаар “Хүүхдийн мөнгө” зэрэг нийгмийн халамжийн хөтөлбөрийн зарлагууд болон хөрөнгө оруулалтад зориулсан нь улсын төсвийг эрдэс баялагийн үнийн тогтворгүй байдалтай холбож байгаа бөгөөд тэр утгаараа урт хугацааны төсвийн алдагдлын эрсдэлийг нэмэгдүүлж байгааг онцолж байна.

Фрейзерийн Хүрээлэнгийн уул уурхайн 2005 оны тайлан (Fraser Institute 2006)-гаар дэлхийн уул уурхайд голлох байр суурь эзэлдэг 64 улсыг бодлого зохицуулалтын чанараар эрэмбэлхэд Монгол улс 33 дугаар байрт буюу дэлхийн уул уурхайн томоохон төлөөлөгчид болох Хойд Америк, Австрали улсын муж улсуудын дараа, Азидаа тэргүүлэгч улс байлаа. Гэвч 2006 онд хийгдсэн уул уурхайн салбарын хууль эрх зүйн зохицуулалтын гэнэтийн өөрчлөлтүүд (Ашигт Малтмалын Тухай шинэчилсэн хууль, Зарим Бүтээгдэхүүний Үнийн Өсөлтийн Албан Татварын Тухай Хууль буюу гэнэтийн ашгийн татварын хууль) нь Монгол улсын нэр хүнд, байр суурьт ихээхэн сөргөөр нөлөөлсөн байна. Фрейзерийн Хүрээлэнгийн уул уурхайн тайлан (Fraser Institute 2008)-гийн 2007 оны эрэмбээр Монгол улс 68 улсаас 61-рт бичигдсэн нь уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалтад ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн гэсэн үг юм.

III. Гэнэтийн ашгийн татварын макро эдийн засгийн нөлөөллүүд

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар (ЗБҮӨАТ)-ын орлого нь 2006 онд Монгол улсын төвлөрсөн төсвийн татварын нийт орлогын 15.7 хувийг, ДНБ-ний 5.6 хувийг, 2007 онд төвлөрсөн төсвийн татварын нийт орлогын 23.6 хувийг, ДНБ-ний 7.8 хувийг тус тус бүрдүүлсэн байна. 2006 онд алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллагуудын төлсөн орлогын албан татвар нь татварын нийт орлогын ердөө 0.3 хувийг, орлогын албан татварын 0.7 хувийг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын 1.5 хувийг л бүрдүүлсэн байна. Мөн оны байдлаар алт олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудын төлсөн ЗБҮӨАТ нь татварын нийт орлогын 0.4 хувийг, орлогын албан татварын 1 хувийг, ЗБҮӨАТ-ын нийт орлогын ердөө 2.6 хувийг бүрдүүлсэн байна. Тус хууль батлагдахаас өмнө өсөх хандлага ажиглагдаж байсан алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварын хэмжээ буурсан байна. Учир нь алт зэсийн үнийн өсөлтийн албан татварыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдох орлогоос хасч тооцохоор “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль”-д заасан байна. Ингэснээр хууль батлагдахаас өмнө тооцогдож байсан татвар ногдох орлогоос гэнэтийн ашгийн татварын хэмжээтэй тэнцэхүйц хэмжээний ихээхэн орлого хасагдаж тооцогдож байгаа болно. Жишээ нь, хууль батлагдахаас өмнөх жилүүдэд алт олборлогчдын төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 4.4-5.1 тэрбум төгрөг байсан бол хууль батлагдсны дараа 3 тэрбум болж буурсан байна.

2001-2005 онуудад Монгол улсын төсвийн орлого дундажаар 19 хувь өсч байсан бол гэнэтийн ашгийн татвараас бий болсон нэмэлт орлого нь 2006 оноос 2008 оны 8 сарын сүүлч хүртэлх хугацаанд Монгол улсын төсвийн орлого дундажаар 48 хувиар өсөхөд ихээхэн нөлөөлсөн байна. Тодруулбал, ЗБҮӨАТ-ын орлого нь 2005-2006 оны татварын орлогын өсөлтийн 41 хувь, төсвийн нийт орлогын 34 хувь, 2006-2007 оны татварын орлогын өсөлтийн 47 хувь, төсвийн нийт орлогын 35 хувийг тус тус бүрдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, 2005 оноос хойшхи Монгол улсын төсвийн нийт орлогын өсөлтийн 1/3 гаруйг дан ганц ЗБҮӨАТ-ын орлого бүрдүүлсэн байна. Төсвийн нийт орлого ийнхүү огцом нэмэгдсэнтэй зэрэгцэн төсвийн нийт зарлага мөн огцом нэмэгдсэн байна. Монгол улсын төвлөрсөн төсвийн нийт зарлага 2004-2005 онд дундажаар 13 хувиар л өсч байсан бол 2006-2008 онуудад дундажаар 56 хувь өссөн байна. Гэнэтийн ашгийн татварын хууль болон түүнийг дагалдан гарсан бусад хууль, журмуудын үр дүнд Монгол улсын төсвийн зарлага гэнэтийн ашгийн татварын хууль батлагдсан үеэс эхлэн огцом буюу жилд дундажаар 56 хувиар нэмэгдсэн байна.

График 1. Төсвийн зарлага, Мөнгөний нийлүүлэлт, Инфляцийн өсөлт



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны эмхэтгэл

Эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдээгүй үед төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлэхэд нийт эрэлт нэмэгдэж үр дүнд нь эдийн засаг дахь ерөнхий үнийн түвшин нэмэгддэг билээ. Энэхүү онол Монголын амьдралд батлагдсан юм. Монгол улсын санхүүгийн зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт маш өндөр хурдацтайгаар нэмэгдэж байгаа нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулах аюултайг олон улсын санхүүгийн байгууллагууд Монгол улсын Засгийн газарт анхааруулж байсан билээ. Нийт мөнгөний тэрхүү өндөр өсөлтийн зэрэгцээ Монгол улсын төсвийн нийт зарлага урьд хожид байгаагүй өндөр хурдацтайгаар өссөний үр дүнд эдийн засаг хэт халалтын байдалд орж

улмаар инфляцийн түвшинг эрс нэмэгдүүлэхэд хүргэсэн юм. 2008 оны 8 сарын эцсийн байдлаар Монгол улсад шилжилтийн хямралын үеэс хойш анх удаа инфляцийн түвшин хамгийн өндөр буюу 25 хувь (өнгөрсөн оны мөн үеэс 34 хувь)-д хүрээд байна.

IV. Алтны үйлдвэрлэл, экспортод үзүүлсэн нөлөөллүүд

Гэнэтийн ашгийн татварын хууль батлагдахаас өмнө буюу 2005 онд Монгол улсад алт олборлогч аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүс 24.1 тонн алт олборлож байсан бол энэ тоо хэмжээ 2006 онд 22.5 тонн, 2007 онд 17.4 тонн болж буурсан байна. Мөн Гаалийн Ерөнхий Газрын статистик мэдээллээр 2005 онд Монгол улс 23.8 тонн алт экспортолсон бол уг тоо хэмжээ 2007 онд 11.5 тонн болж огцом буурсан байна.


График 2. Алтны борлуулалт ба экспорт, 2005-2007



Эх үүсвэр: Монгол Банк, Гаалийн Ерөнхий Газар

График 3 дахь алтны үйлдвэрлэлийн динамикаас харахад 1990-2007 онуудад алтны үйлдвэрлэлд 2 удаагийн л уналт ажиглагдсан бөгөөд хоёуланд нь алтны дэлхийн зах зээлийн үнэ биш алтны салбартай холбоотой бодлого, зохицуулалтын өөрчлөлт болон геологи, технологийн нөхцөлийн өөрчлөлт гэсэн 2 хүчин зүйл л нөлөөлсөн байна. Тодруулбал, 2001-2003 онуудад болсон алтны үйлдвэрлэлийн уналтад алтны шороон ордуудын тоо болон нөөц багассан нь нөлөөлсөн байхад 2006-2007 онуудын уналтад алтны салбартай холбоотой бодлого, зохицуулалт буюу тодруулбал, алтны үнийн өсөлтийн албан татварын тухай хууль нөлөөлсөн нь тодорхой байна.

График 3. Монгол улс дахь алт олборлолт (кг), 1990-2007



Эх үүсвэр: АМГТХЭГ, КИТСО

Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газрын 2006 оны тайланд дурдснаар алт олборлолтыг тэргүүлж буй 10 аж ахуйн нэгжүүдийн олборлосон алтны хэмжээ нь нийт алт олборлолтын 82 хувийг, тэр дундаа гадаадын хөрөнгө оруулалттай 2 аж ахуйн нэгж (Бороо Гоулд, Алтан Дорнод)-ийн олборлосон алтны хэмжээ нийт дүнгийн 61 хувийг эзэлж байна. 2005-2007 онуудад тус хоёр аж ахуйн нэгжийн алт олборлолт харьцангуй тогтвортой байсан байхад алтны нийт үйлдвэрлэлийн хэмжээ 6.7 тонноор буурсан байна. Нөгөө талаар хэдийгээр “Бороо Гоулд” компанийн алт олборлолт 2007 онд бага зэрэг буурсан ч энэ нь алтны үнийн өсөлтийн татвартай холбоогүй юм. Учир нь Монгол улсын Засгийн Газрын тус компанитай хийсэн “Тогтвортой байдлын гэрээ”-ний дагуу тус компани нь гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөгдөж байгаа юм. Эндээс харахад, мөн алт үйлдвэрлэгч 2 том аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн нийт дүнд эзлэх хувь өсч байгаагаас харахад алтны үнийн өсөлтийн татварын хууль нь Монгол улсад алт олборлож буй дотоодын жижиг, дунд аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст сөргөөр нөлөөлсөн нь тодорхой байна. Тус хууль батлагдахаас өмнө буюу 2005 онд “Бороо Гоулд”, “Алтан Дорнод”-оос бусад аж ахуйн нэгжүүд 12.1 тонн буюу нийт алт олборлолтын тал хувийг олборлож байсан бол 2007 оны байдлаар 5.6 тонн болж 2 гаруй дахин буурч нийт алт олборлолтын дөнгөж 32 хувийг эзлэх болсон байна.

Гэнэтийн ашгийн 68 хувийн татвар ногдуулсан үеэс хойш Монгол улсын эрдэнэсийн санд тушаагдах алтны хэмжээ эрс буурсан, мөн Монгол улсын экспортын орлогыг бүрдүүлэгч гол эх үүсвэрүүдийн нэг болох алтны экспорт 2 дахин буурсан нь энэ хэмжээгээр Монгол улсын албан секторын хэмжээ хумигдаж албан бус буюу далд эдийн засгийн хэмжээ нэмэгдсэнийг харуулж байгаа юм. Хэрэв алтны үйлдвэрлэл, экспорт 2005 оны түвшиндээ байх

байсан гэж үзвэл Монгол улс өнгөрсөн 2 жилийн хугацаанд 20.6 тонн алт буюу 565 сая ам.доллар (нэг унц алтны дундаж үнэ 850 ам.доллар гэж үзвэл)-ын үйлдвэрлэл, экспортын боломжийг алдсан байна гэсэн үг юм.

V. Алт олборлолтын өөрийн өртгийн шинжилгээ

Алтны зах зээлийн үнэ нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хэмжээгээр тодорхойлогдохоос гадна алтны үйлдвэрлэлийн зардлаас ихээхэн хамаарна. Алтны үйлдвэрлэлийн нэгжийн өөрийн өртөг нь алт олборлогчийн үйлдвэрлэлийн технологи, орцуудын нэгжийн үнэ, уул геологийн нөхцөл зэрэг олон хүчин зүйлүүдээс хамааран өөрчлөгддөг. Эдгээр хүчин зүйлүүд алт олборлогчдын хувьд төдийгүй тухайн алт олборлогчийн алтны орд тус бүрд харилцан адилгүй байж болно. Жишээ нь, томоохон алт олборлогчдын хувьд хамгийн сүүлийн үеийн зардал багатай технологи ашиглаж байхад жижиг үйлдвэрлэгчид нэгжийн зардал өндөр, харьцангуй хоцрогдсон технологи ашиглах нь олонтаа. Мөн томоохон алт олборлогчдын хувьд олон ордод нэгэн зэрэг алт олборлох санхүүгийн боломж өндөртэй байх боловч орд тус бүрийн уул техникийн нөхцөл харилцан адилгүй байдгаас болж орд тус бүрийн алт олборлолтын нэгжийн зардал харилцан адилгүй байна.

Монгол улсад алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн нэгжийн зардлын шинжилгээг хийх үүднээс түүвэр судалгаа хийлээ. Судалгаанд хамрагдсан алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн нэг унц алт үйлдвэрлэлийн дундаж өөрийн өртөг нь 2006 онд 584 ам.доллар байсан бол 2007 оны байдлаар 685 ам.доллар болж нэмэгдсэн байна. Ялангуяа том болон дунд түвшний алт үйлдвэрлэгчдийн дундаж өөрийн өртөг 200-аад ам.доллараар нэмэгдсэн байна. Хэдийгээр энэ нь зарим талаар үнэн бодит байдлаас бага зэрэг хазайх хазайлт байгааг үгүйсгэхгүй ч алтны үнийн өсөлтийн албан татвар ногдуулах суурь үнээс давсан буюу тун ойр байгааг харуулж байна. Ийм нөхцөлд алт олборлогчдын хувьд нийт татварын ачаалал өндөр байж, тэр хэрээрээ татвараас зайлсхийх, орлогоо нуун дарагдуулах зэрэг хууль бус үйлдэлүүдийг хийх магадлал өндөр байх нь ойлгомжтой юм.

Хүснэгт 1. Нэг унц алтны дундаж өөрийн өртөг (ам.доллар)

	2006-I	2006-II	2006	2007
Жижиг	1,098.74	772.14	788.22	707.60
Дунд	502.15	580.77	581.74	781.73
Том	520.37	361.52	380.89	579.90
ДУНДАЖ	584.93	571.48	583.61	684.64

Алт, зэсийн үнийн өсөлтийн татварыг тогтоохдоо суурь болгон авч буй үнэ нь (жишээ нь, нэг унц алтны хувьд 500 ам.доллар) эдийн засгийн суурь үзүүлэлт болох инфляцийн түвшинтэй уялдаагүй үл өөрчлөгдөхөөр тогтоогдсон нь тодорхой хугацааны дараа уг татварын дарамт инфляцийн хувьтай хамт нэмэгдэх нь гарцаагүй юм. Алт төдийгүй ямар ч үйлдвэрлэлийн хувьд бүтээгдэхүүний үнэ зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тусгал болохоос гадна үйлдвэрлэлийн зардлын тусгал болдог билээ. Тийм ч учраас техник технологийн мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй нөхцөлд үйлдвэрлэлийн зардалаа дагаад бүтээгдэхүүний үнэ байнга өсөн нэмэгдэх зүй тогтолтой юм. Учир нь үйлдвэрлэлийн орцуудын үнэ цаг хугацааны хувьд байнга өсөн нэмэгдэх хандлагатай байдаг.

Алт үйлдвэрлэлийн хувьд түлш шатахуун, цахилгаан эрчим хүч, хөдөлмөр, үндсэн хөрөнгийн элэгдэл, сэлбэг хэрэгсэл, аюулгүй ажиллагааны зэрэг олон төрлийн зардлууд гардаг бөгөөд алтны үйлдвэрлэлд хүнд машин механизм үндсэн техник болдог учраас түлш шатахууны зардал үйлдвэрлэлийн нэгжийн зардалд зонхилох байр суурийг эзэлдэг. Судалгаанд хамрагдсан алт олборлогчдын нэг унц алтны өөрийн өртөгийн 1/3 гаруй хэсгийг түлшний зардал эзэлдэг бөгөөд энэ хувь хэмжээ харьцангуй тогтвортой байна. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлд түлш шатахуун зэрэг нефть бүтээгдэхүүн өргөн хэрэглэгддэг учраас алт олборлолтын өөрийн өртөг, газрын тосны үнэтэй шууд хамааралтайгаар өөрчлөгддөг.

Хүснэгт 2. Нэг унц алтны өөрийн өртөгт түлшний зардлын эзлэх хувь

	2006-I	2006-II	2006	2007
Жижиг	17%	28%	21%	33%
Дунд	26%	35%	35%	45%
Том	49%	43%	45%	34%
ДУНДАЖ	35%	36%	37%	38%


Дэлхийн алт үйлдвэрлэгч компаниудын алтны үйлдвэрлэлийн нэгжийн зардлын динамикт дүн шинжилгээ хийх, газрын тосны үнэтэй хэрхэн хамааралтайгаар өсч байгааг батлах үүднээс дэлхийд алт олборлолтоор тэргүүлэгч 7 компанийг сонгон авч 2000-2007 онуудын санхүүгийн тайланг авч үзлээ. Эдгээр 7 компаниудын нэг унц алт олборлолтын өөрийн өртөгийн дундаж нь 2001 онд 150 орчим ам.доллар байсан бол 2007 оны байдлаар 2 гаруй дахин нэмэгдэж 310 орчим ам.доллар болсон байна. Стандарт хазайлтаас харвал нэг унц алтны өөрийн өртөг 2007 оны байдлаар 200-400 ам.доллар байна.

Нэг барель түүхий нефть 1998 оны эцсээр 9.12 ам.доллар (сүүлийн 10 жилийн хамгийн доод үнэ) байсан бол 2008 оны 6 сарын 6-ны байдлаар 139 ам.долларт хүрч 15 дахин нэмэгдсэн. Алт, зэсийн үнийн өсөлтийн Гэнэтийн

Ашгийн Татварын хууль батлагдахаас өмнөх үе буюу 2006 оны 5 сард хар алтны үнэ 65 орчим ам.доллар байсан бол түүнээс хойш 2 дахин нэмэгдээд байна. 2001 онд дэлхийн зах зээл дээрх нэг унц алтны үнэ 271 ам.доллар байсан бол 2008 оны 7 сарын байдлаар 942 ам.долларт хүрч (2007 оны 3 сард 1050 ам.долларт хүрсэн) 3.5 дахин нэмэгдээд байна. Нэг унц алтны үйлдвэрлэлийн өөрийн өртөг, газрын тосны үнүүдийн хамаарал буюу корреляцийн коэффициент (R^2) 0.85 байгаа нь маш өндөр үзүүлэлт бөгөөд эдгээр хоёр эрдэс түүхий эдүүдийн хоорондын хамаарал өндөр байгааг харуулж байна.

Газрын тосны үнэ 2008 онд 99.88 ам.доллар, 2009 онд 160.91 ам.доллар байна гэж зарим эх сурвалжууд прогнозолж байна. Эдгээр газрын тосны үнийн прогнозыг үндэс болговол нэг унц алтны үйлдвэрлэлийн өөрийн өртөг 2008 онд 373.97 ам.доллар, 2009 онд 547.24 ам.доллар байхаар байна. Газрын тосны үнийн өнөөдрийн түвшинг авч үзэн прогнозуудыг бага зэрэг нэмэгдүүлэхэд, жишээ нь нэг барель газрын тосны үнийг 2008 онд 140 ам.доллар гэж үзвэл нэг унц алтны үйлдвэрлэлийн өөрийн өртөг 487.87 ам.доллар болохоор байна.

График 4. Алт ба газрын тосны үнийн динамик (ам.доллар), 1997-2008



Эх үүсвэр: KITCO, Energy Information Administration

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ сүүлийн 5-6 жилд байнга тасралтгүй өсч байгаа учраас нефть бүтээгдэхүүнээ 100 хувь импортолдог Монгол улсад ч мөн адил нефть бүтээгдэхүүнүүдийн үнэ байнга өсч байна. "Гэнэтийн ашгийн татварын хууль" батлагдахаас өмнө буюу 2006 оны эхнээс өнөөг хүртэл уул уурхайн үйлдвэрлэлд өргөн хэрэглэгддэг нефть бүтээгдэхүүнүүд болох А-80, А-92 бензин болон Дизель түлшний үнүүд 2 дахин өсөөд байна. Нефть бүтээгдэхүүнүүдийн үнэ ийм өндөр хувиар өсч байгаатай хамт нэг унц алтны үйлдвэрлэлийн нэгжийн зардал өсөх нь зайлшгүй юм. 2006-2008 оны хооронд түлшний зардлыг дундажаар 2 дахин өссөн гэж үзэн нэг унц алтны өөрийн өртгийн өөрчлөлтийг тооцоолж үзэхэд өөрийн өртөг

60-84 хувиар өсч байна. Эндээс харахад зөвхөн түлшний зардлын огцом өсөлтөөс л гэхэд олон арван жижиг, дунд алт олборлогчдын нэгжийн зардал нь гэнэтийн ашгийн татвар тооцох суурь үнэ болох 500 ам.долларт хүрсэн эсвэл хэдийн давсан гэсэн үг юм.

Хүснэгт 3. Нефть бүтээгдэхүүний үнийн өсөлт, 2005-2008

	2005-2006	2006-2007	2006-2008(Q3)
A-80	6%	27%	100%
A-92	15%	24%	111%
Дизель	9%	19%	99%

Эх үүсвэр: Статистикийн эмхэтгэл 2005-2007

VI. Алтны үнийн мэдрэмжийн шинжилгээ

Гэнэтийн ашгийн татварын хууль нь нэг унц алт үйлдвэрлэлийн өөрийн өртөг харилцан адилгүй байгаа аж ахуйн нэгжүүд юмуу тухайн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн нэгжийн зардал ордуудын хувьд харилцан адилгүй байх үед татварын ачаалал хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулах үүднээс симуляци шинжилгээ хийж үзлээ. Нэг унц алт үйлдвэрлэлийн өөрийн өртгийг Гэнэтийн ашгийн татвар тооцох суурь үнээс бага, их, тэнцүү байх үндсэн хувилбаруудаас гадна Гэнэтийн ашгийн татваргүй тохиолдлыг мөн авч үзлээ. Татварын нийт хувийг компани тус бүрт тооцохдоо дараах урьдчилсан нөхцөлүүдийг компани А-Е бүгдэд нь ижил байхаар авч үзсэн болно. Үүнд:

- 1) Нэг унц алтны үнэ 900 ам.доллар байна.
- 2) Одоогийн үйлчилж буй (2006 онд батлагдсан) "Ашигт малтмалын тухай хууль"-ийн дагуу нөөц ашигласны төлбөр 5% байна.
- 3) Компани А-Е нь бүгд жилд 525 кг хүртэл хэмжээний алт олборлодог буюу аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах орлого нь 3 тэрбум төгрөгөөс бага байна. Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь 10% байна.
- 4) Тооцооллыг энгийн болгох үүднээс бид нэг унц алт үйлдвэрлэж борлуулсан гэж үзэв. Мөн нийт татвар гэдэгт зөвхөн нөөц ашигласны төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын татвар, гэнэтийн ашгийн татварыг оруулав.

Хүснэгт 4. Симуляцийн үр дүн - Татварын нийт хувьд

(Мөнгөний нэгжийг ам.доллараар авав)

	Компани А	Компани В	Компани С	Компани D	Компани E
1 унц алтны өөрийн өртөг	500.00	500.00	450.00	350.00	527.00
1 унц алтны Дэлхийн зах зээлийн үнэ	900.00	900.00	900.00	900.00	900.00
Нөөц ашигласны төлбөр	45.00	45.00	45.00	45.00	45.00
Гэнэтийн ашгийн татвар		272.00	272.00	272.00	272.00
ААНБ-ын Орлогын Албан татвар	35.50	8.30	13.30	23.30	5.60
Бүх татвар, төлбөр	80.50	325.30	330.30	340.30	322.60
Компанид үлдэх ашиг	319.50	74.70	119.70	209.70	50.40
Татварын нийт хувь	20.13%	81.33%	73.40%	61.87%	86.49%

Эхлээд Компани А ба В-г харьцуулан авч үзье. Энд гэнэтийн ашгийн татвар төлөх үед болон төлөхгүй тохиолдолд татварын хувь хэмжээ ямар байхыг авч үзлээ. Мөн энэ хоёр компанийн хувьд нэг унц алтны үйлдвэрлэлийн өөрийн өртөг ижил 500 ам.доллар байна. Хүснэгт 4-өөс харахад Гэнэтийн ашгийн татвар нь компанийн татварын нийт хувь хэмжээг 61 пунктээр нэмэгдүүлж байна. Компани С болон D-ийн хувьд нэг унц алт үйлдвэрлэлийн өөрийн өртөг 500 ам.доллараас бага байгаа учраас компанийн татварын нийт хувь Компани В-ээс бага байна. Жишээ нь, нэг унц алтны олборлолтын өөрийн өртөг 350 ам.доллар байгаа компанийн хувьд нөөц ашигласны төлбөр, гэнэтийн ашгийн татвар, орлогын албан татвар нь нийлээд 61.87% болж байна гэсэн үг юм. Хэрэв алт олборлогч аж ахуйн нэгжийн нэг унц алт олборлолтын өөрийн өртөг нь гэнэтийн ашгийн татвар тооцох суурь үнэ болох 500 ам.доллараас их байвал компанийн төлөх татварын нийт хувь маш өндөр байхаар харагдаж байна. Жишээ нь, Компани E-ийн хувьд нэг унц алт олборлолтын өөрийн өртөг алтны үнийн өсөлтийн татвар тооцох суурь үнэ болох 500 ам.доллараас их буюу 527 ам.доллар байгаа бөгөөд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нөөц ашигласны төлбөр, гэнэтийн ашгийн татвар гэсэн ердөө 3 төрлийн татварт 86.5 хувийн татвар төлөхөөр байна. Эдгээр 3 төрлийн татвараас гадна алт олборлогч аж ахуйн нэгжүүд үндсэн хөрөнгийн, тээврийн хэрэгслийн, газар, ус ашигласны зэрэг 20-иод төрлийн татвар, төлбөр, хураамж төлөх бөгөөд нийт хувь хэмжээг бодож үзвэл татварын ерөнхий түвшин асар өндөр байх нь ойлгомжтой юм.

Дээрх симуляци шинжилгээг бид алтны үнэ бүх тохиолдолд тогтмол 900 ам.доллар буюу харьцангуй өндөр байхаар авч үзсэн. Тэгвэл алтны үнэ өөрчлөгдөх бүрт алт олборлогчдын хувьд улсын төсөвт төлж буй 3 төрлийн татварын нийт хувь дагаад өөрчлөгдөнө. Өөрөөр хэлбэл, дэлхийн зах зээл дээрх

алтны үнэ буурах үед тэдгээр татварын нийт хувь улам нэмэгдэнэ гэсэн үг юм. Дэлгэрэнгүйг бид алтны үнийн өөрчлөлтийн мэдрэмжийн шинжилгээгээр доор харуулна. Өмнөх шинжилгээнд авч үзсэн А-аас Е хүртэлх 5 тохиолдлыг алтны дэлхийн зах зээлийн үнэ 600-аас 1000 ам.доллар хүртэлх түвшинд ямар байхыг авч үзэн алтны үнэ тус бүрт татварын нийт хувь хэмжээ хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулна. Үр дүнг Хүснэгт 5 болон График 5-д харуулав.

Хүснэгт 5. Алтны үнэ ба Татварын нийт хувийн хамаарал

Алтны үнэ	A	B	C	D	E
600.0	37%	98%	69%	45%	131%
650.0	30%	91%	71%	50%	108%
700.0	26%	87%	72%	54%	99%
750.0	24%	85%	72%	57%	94%
800.0	22%	83%	73%	59%	90%
850.0	21%	82%	73%	60%	88%
900.0	20%	81%	73%	62%	86%
950.0	20%	81%	74%	63%	85%
1,000.0	19%	80%	74%	64%	84%

Компани А-ийн хувьд гэнэтийн ашгийн татвар төлөхгүй учраас алтны үнэ өсөх бүрт татварын нийт хувь буурч байна. Жишээ нь, алтны үнэ 600 ам.доллар байх үед татварын нийт хувь 37% байсан бол алтны үнэ 1000 ам.долларт хүрэхэд татварын нийт хувь 19% болж буурч байна. Компани В-ийн хувьд нэг унц алт үйлдвэрлэлийн өөрийн өртөг Компани А-ийнхтай адил 500 ам.доллар боловч гэнэтийн ашгийн татвар төлж байгаа учраас татварын нийт хувь маш өндөр байна. Нэг унц алтны үнэ буурах тусам Компани В-ийн татварын нийт хувь нэмэгдэж байна. Жишээ нь, алтны үнэ 950 ам.доллар байх үед Компани В-ийн татварын нийт хувь 81% байсан бол алтны үнэ буурч 600 ам.долларт хүрэх үед татварын нийт хувь 98% болж байна. Ялангуяа алт олборлогчийн нэг унц алт олборлолтын өөрийн өртөг 500 ам.доллараас их үед татварын нийт хувь бүр илүү өндөр байна. Жишээ нь, Компани Е-ийн хувьд нэг унц алт олборлолтын өртөг 527 ам.доллар байгаа учраас татварын нийт хувь аль ч үнийн үед хамгийн өндөр буюу 84-131% байна.

Компани С болон D-ийн хувьд нэг унц алт олборлолтын өөрийн өртөг гэнэтийн ашгийн татвар тооцох суурь үнэ буюу 500 ам.доллараас бага байгаа учраас хэдийгээр гэнэтийн ашгийн татвар төлөх ч гэсэн татварын нийт хувь Компани Е болон В-тай харьцуулахад доогуур байна. Жишээ нь, нэг унц алтны өөрийн өртөг хамгийн бага түвшинд буюу 350 ам.доллар байх Компани D-ийн хувьд алтны үнэ 600 ам.доллар байх үед татварын нийт хувь нь 45% байсан бол алтны үнэ өсч 1000 ам.долларт хүрэхэд татварын нийт хувь нь 64% болж өсч байна. Дээрх тооцоонуудаас харахад алтны үнэ татварын нийт хувь хоорондоо

эсвэл шууд эсвэл урвуу хамааралтай нь харагдаж байна. Бүр тодруулбал, алт олборлолтын өөрийн өртөг 500 ам.доллараас их үед алтны үнэ татварын нийт хувь хоёр урвуу хамааралтай байхад 500 ам.доллараас бага үед шууд хамааралтай байна. Үүнийг бид татварын нийт хувийн алтны үнэ, алтны өөрийн өртөг гэсэн 2 хүчин зүйлээс хамаарах хамаарлын загварыг гарган, татварын алтны үнийн мэдрэмжийг тооцоолон гаргах замаар дэлгэрэнгүй тайлбарлаж болно.

Бидний тооцоонд татварын нийт хувь буюу 3 төрлийн татварын татвар тооцох орлогод эзлэх хувийг дараах байдлаар тодорхойлсон болно.

$$T = \frac{CIT + R + WPT}{p - c} \quad [1]$$

Энд, T – татварын нийт хувь, CIT – аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, R – нөөц ашигласны төлбөр, WPT – Гэнэтийн ашгийн татвар, p – нэг унц алтны үнэ, c – нэг унц алтны өөрийн өртөг бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг (нэг унц алт олборлосон үед гэж хялбаршуулан авч үзэв) татвар ногдох орлого ($p - c$)-оос нөөц ашигласны төлбөр, гэнэтийн ашгийн татварыг хасч үлдсэн дүнгээс 10 хувийн татвар авахаар тооцоолсон бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.

$$CIT = [p - c - R - WPT] * 10\% \quad [2]$$

Нөөц ашигласны төлбөр нь борлуулалтын орлогын дүнгээс 5 хувиар тооцоолох тул дараах байдлаар тодорхойлогдоно.

$$R = p * 5\% \quad [3]$$

Гэнэтийн ашгийн татвар нь борлуулсан алтны үнэ, суурь үнэ болох 500 ам.долларын зөрүүгээс 68 хувиар тооцох бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.

$$WPT = (p - 500) * 68\% \quad [4]$$

Тэгшитгэл 2, 3, 4-үүдийг тэгшитгэл 1-д орлуулан нэгтгэвэл татварын нийт хувь, алтны үнэ, алтны өөрийн өртгийн хамаарлын загвар нь дараах байдалтай болно.

$$T = \frac{0.757p - 356}{p - c} \times 100\% \quad [5]$$

Энэхүү загвараас нэгж алтны үнийн өөрчлөлтөөс татварын нийт хувийн өөрчлөгдөх өөрчлөлт буюу ахиуц татвар (marginal tax rate) дараах байдалтай болно.


$$MTR = \frac{-0.757c + 356}{p^2 - 2pc + c^2} \quad [6]$$

Эндээс 2 тохиолдол гарна. Үүнд:

a) $-0.757c + 356 > 0 \Rightarrow c < 470.27$

b) $-0.757c + 356 < 0 \Rightarrow c > 470.27$

График 5. Алтны үнэ ба Татварын нийт хувийн хамаарал



Өөрөөр хэлбэл, нэг унц алт олборлолтын өөрийн өртөг 470.27 ам.доллараас бага үед ахиуц татвар эерэг буюу татварын нийт хувь алтны үнэ хоёр хоорондоо шууд хамааралтай байна. Эсрэг тохиолдолд урвуу хамааралтай байна. Энэ нь бидний тооцоонд авсан 5 тохиолдолуудаар батлагдаж байна. Компани А, В, Е-ийн тохиолдол буюу нэг унц алтны өөрийн өртөг 470.27 ам.доллараас их байгаа үед алтны үнэ нэмэгдэх үед татварын нийт хувь буурч байна. Компани С болон D –ийн тохиолдолууд буюу нэг унц алтны өөрийн өртөг 470.27 ам.доллараас бага байгаа үед алтны үнэ нэмэгдэх үед тэдгээр компаниудын төлөх татварын нийт хувь өсч байна. Энэ бүхэн юу харуулж байна вэ? Дэлхийн зах зээл дээрх алтны үнийн динамик нь алт үйлдвэрлэгчдийн хувьд харилцан адилгүй нөлөөлж байна. Үйлдвэрлэлийн технологи хуучирсан, өртөг зардал өндөртэйгөөр нэг унц алтыг олборлож байгаа үйлдвэрлэгчдийн хувьд алтны үнийн өсөлт үйлдвэрлэгчдийн татварын нийт хувийг бууруулах боломжтой нь харагдаж байна. Харамсалтай нь өнөөгийн нөхцөлд буюу алтны үнэ буурч байгаа үед тэдгээр алт олборлогчдын

хувьд татварын нийт хувь нэмэгдэж, татварын ачаалал илүү хүндрэх нь дээрх шинжилгээнүүдээс харагдаж байна.

VII. Дүгнэлт ба зөвлөмжүүд

Сүүлийн жилүүдийн дэлхийн зах зээл дээрх эрдэс түүхий эдийн ялангуяа Монгол улсын экспортын орлогын 70 гаруй хувийг бүрдүүлдэг алт, зэс, цайр, нүүрс зэрэг метал болон эрчим хүчний түүхий эдийн үнийн огцом өсөлтүүдээс үүдэн 2006 оны 5 сард Монгол улсын Их Хурлаас алт болон зэсийн баяжмалын үнийн өсөлтийн 68 хувийн албан татварыг баталсан нь өнөөг хүртэл маргаантай олон асуудлуудын эх үүсвэр болж, Монгол улсын уул уурхайн салбарын татварын орчны өрсөлдөх байдал, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, бүр цаашилбал макро эдийн засгийн тогтвортой байдалд ч сөрөг нөлөө үзүүлж эхэллээ.

Хэдийгээр “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” нь зөвхөн алт болон зэсийн баяжмал гэсэн хоёрхон металын хувьд хамаарч байгаа ч Монгол улс дахь алт олборлогчдод илүү сөрөг нөлөөтэй хууль болсон нь дээрх судалгаагаар нотлогдож байна. Учир нь зэсийн баяжмалыг өнөөгийн байдлаар Монгол улсын төрийн өмчит цорын ганц үйлдвэр дангаараа үйлдвэрлэж байгаа тул тус хуулиар тогтоосон албан татвар нь ердөө төрийн нэг халааснаас нөгөөд л орж байгаа асуудал юм. Иймээс энэхүү судалгаа нь тус хуулийн алт олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлсэн нөлөөг түлхүү судаллаа.

Гэнэтийн ашгийн татвар нь Монгол улсын уул уурхайн салбарын татварын орчны өрсөлдөх чадварыг эрс бууруулж, цаашилбал Монгол улсын төсвийн тогтворгүй байдлыг нэмэгдүүлэх эрсдэлийг агуулж байгааг олон улсын судлаачид зөвлөж байна. Мөн түүнчлэн тус хуулийн үр дүнд Монгол улсын уул уурхайн салбарын гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын дундах нэр хүнд, байр суурь эрс муудаж байгааг олон улсын байгууллагуудын судалгаа харуулж байна.

Алтны үнийн өсөлтийн 68 хувийн татвар ногдуулах болсноос хойш Монгол улсын алт олборлолтын хэмжээ болон экспорт мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан. 2005 онд 24.1 тонн алт олборлож 23.8 тонн алт экспортолж байсан бол 2007 оны байдлаар үйлдвэрлэл 7 орчим тонн, экспорт 11 гаруй тонноор буурсан байна. Тус татвар нь Монгол улсын ялангуяа жижиг, дунд алт олборлогчдод илүү их сөргөөр нөлөөлсөн байна. 2005 онд Монголын алт олборлогчид 12.1 тонн буюу нийт алт олборлолтын тал хувийг олборлож байсан бол, 2007 оны байдлаар 5.6 тонн болж бууран нийт алт олборлолтын ердөө 32 хувийг үйлдвэрлэх болсон байна.

Алт олборлогчдын үйлдвэрлэлийн нэгжийн өөрийн өртөг үйлдвэрлэлийн орцуудын үнийн өсөлтүүдээс хамааран байнга өсч байна. Дэлхийн топ 7 алт олборлогчдын нэг унц алт үйлдвэрлэлийн өөрийн өртөг 2005 онд 150 орчим ам.доллар байсан бол 2007 оны байдлаар 310 ам.долларт хүрч 2 гаруй дахин өсөөд байна. Тэгвэл судалгаанд хамрагдсан Монгол улсын алт

олборлогчдын хувьд нэг унц алтны өөрийн өртөг 2005 онд 582 ам.доллар байсан бол 2007 онд 684 ам.доллар болж өссөн байна.

Алт олборлолтын үйлдвэрлэлийн зардалд түлшний зардал голлох хувийг эзэлдэг. Судалгаанд хамрагдсан алт олборлогчдын хувьд нэг унц алт олборлолтын өөрийн өртгийн 35-38 хувийг түлшний зардал эзэлж байна. Гэнэтийн ашгийн татварын хууль батлагдахаас өмнөх үе буюу 2005 оноос хойш өнөөг хүртэл алтны үйлдвэрлэлд ашиглагддаг үндсэн түлш, шатахуунуудын үнэ 2 дахин өссөн байна. Үүний үр дүнд алтны үйлдвэрлэлийн нэгжийн зардал огцом нэмэгдэж, магадгүй зарим алт олборлогчдын хувьд алтны үнийн өсөлтийн 68 хувийн татвар ногдуулах суурь үнэ 500 ам.доллараас ч давсан нь тодорхой юм.

Алт олборлогчдын нэгжийн өөрийн өртөг харилцан адилгүй байх үед Алтны үнийн өсөлтийн 68 хувийн татварын ачаалал хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулах симуляци шинжилгээ хийж үзэхэд нэгжийн өртөг хамгийн бага тохиолдолд татварын нийт хувь 61.8%, алтны нэгжийн өөрийн өртөг хамгийн өндөр тохиолдолд татварын нийт хувь 86.5% болж байна. Татварын нийт хувьд зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гэнэтийн ашгийн татвар, нөөц ашигласны төлбөр гэсэн 3 төрлийн татварыг тооцсон болно. Бусад төрлийн бүх татвар, хураамж, төлбөрүүдийг оролцуулбал татварын нийт хувь илүү өндөр гарах нь тодорхой юм.

Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ байнга өөрчлөгдөж байгаа учраас үнийн өөрчлөлтийн мэдрэмжийн судалгааг хийж, алтны үнэ өөрчлөгдөхөд татварын нийт хувь хэрхэн өөрчлөгдөхийг шинжиллээ. Шинжилгээний үр дүнгээс харахад алтны нэгжийн өөрийн өртөг 470 ам.доллараас их үед алтны үнэ, татварын нийт хувийн өөрчлөлт урвуу хамааралтай, эсрэг тохиолдолд шууд хамааралтай байна. Алтны үйлдвэрлэлийн харьцангуй шинэ технологи ашиглаж үйлдвэрлэлийн нэгжийн зардал харьцангуй бага томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьд нэгжийн өөрийн өртөг 470 ам.доллараас бага гэж үзвэл алтны үнэ нэмэгдэх үед татварын нийт хувь нэмэгдэхээр байна. Харин нэгжийн өөрийн өртөг харьцангуй өндөр байдаг жижиг, дунд алт олборлогчдын хувьд нэгжийн өөрийн өртөг 470 ам.доллараас их байгаа гэж үзвэл алтны үнэ буурах үед татварын нийт хувь буюу ачаалал нэмэгдэхээр байна.

Алтны үнийн өсөлтийн татварын хуулийн эдийн засгийн нөлөө, үндэслэлийн судалгаа, шинжилгээнүүдийн үр дүнд тулгуурлан дараах бодлогын зөвлөмжүүдийг дэвшүүлж байна:

- Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль"-ийн татварын хувь хэмжээг эргэн харж үзэх буюу оновчтой хувь хэмжээ тогтоох. Учир нь татварын хувь хэмжээ хэт өндөр бол богино хугацаанд татвар төлөгчид харьцангуй их татварын орлого төсөвт оруулах боловч урт хугацаанд татвар төлөгчдийн тоо буюу татварын суурь багасч төсөвт орох нийт орлого буурдаг. Мэдээж татварын хувь хэмжээ хэт доогуур байвал хэдийгээр татварын суурь өргөжих сайн талтай ч гэсэн боломжит

ихээхэн орлогыг алдах сул талтай. Иймээс татварын хувь хэмжээг татварын орлогыг хамгийн их байлгах түвшинд буюу оновчтой хувь хэмжээ тогтоох ёстой.

- Монгол улсын төсвийн нийт орлого, ялангуяа аж ахуйн нэгж байгууллагын татварын орлогыг хамгийн их түвшинд байлгах татваруудын зохистой харьцааг тогтоох үүднээс “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль”-ийг өөрчлөх. Учир нь Гэнэтийн ашгийн татвар нь татвар ногдох орлогоос хасагдаж тооцогдож байгаа учраас уг татвар нь алт олборлогчид болон зэсийн баяжмал үйлдвэрлэгчдийн татвар ногдох орлого, улмаар төсөвт төвлөрүүлэх орлогыг бууруулах сөрөг талтай юм.
- “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль”-ийг хүчингүй болгох, эсвэл алттай холбогдох заалтуудыг өөрчлөн найруулах. Тодруулбал, алтны үнийн өсөлтийн татвар тооцох суурь үнэ болох 500 ам.долларыг инфляцийн түвшинтэй уялдуулан жил бүр өөрчлөгдөж байхаар тогтоох зайлшгүй шаардлагатай юм.

Ашигласан ном зүй:

Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газар. 2007. Монгол улсын уул уурхайн ашигт малтмалын салбарын тайлан.

Chennells, Lucy, 1997. The windfall tax. *Fiscal Studies*, 18 (3), 279-291.

Fraser Institute, 2006. Survey of mining companies 2005/2006. Vancouver, BC, Canada.

Fraser Institute, 2008. Survey of mining companies 2007/2008. Vancouver, BC, Canada.

Internal Revenue Service. 2002. Coordinated issue utility industry United Kingdom windfall tax. <http://www.irs.gov/businesses/article/0,,id=181765,00.html>

Lazzari, Salvatore, 1990. The windfall profits tax on crude oil: Overview of the issues. *CRS Report for Congress*, Washington DC.

Lazzari, Salvatore, 2006. The crude oil windfall profit tax of the 1980s: Implications for current energy policy. *CRS Report for Congress*, Washington DC.

Otto, James, 2007. Competitive position of Mongolia's mineral sector fiscal system: the case of a Model Copper Mine. Boulder, Colorado.

Sunley, E., Daehaeng, K., M. Villafuerte, 2007. The fiscal regime for the mining sector and the Development Fund. International Monetary Fund. Washington DC.

Тоо мэдээллүүд:

“Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” 2006

“Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль” шинэчилсэн найруулга, 2006

Үндэсний Статистикийн Хороо. Статистикийн эмхэтгэл 2005-2007.

Гаалийн Ерөнхий Газар. Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл 2005-2007

AngloGold Ashanti. Financial statements 2000-2007. www.anglogold.com

Barrick Gold Corporation. Financial statements 2000-2007. www.barrick.com

Freeport McMoRan Copper & Gold Inc. Financial statements 2000-2007. www.fcx.com

Goldcorp Inc. Financial statements 2000-2007. www.goldcorp.com

Gold Fields Limited. Financial statements 2000-2007. www.goldfields.co.za

Newcrest Mining Limited. Financial statements 2000-2007. www.newcrest.com.au

Newmont Mining Corporation. Financial statements 2000-2007. www.newmont.com